**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2022 ОНЫ 07 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 07 дугаар сарын 29 Улаанбаатар хот

| Д\Д | Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан | Цаашид авч хэрэгжүүлэх арга зам | Оноо |
|---|---|---|---|---|
| **Үүрэг, даалгавар НЭГ**: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/853 дугаар захирамжийн дагуу хэрэгжилтийг хангаж ажиллах. Хийгдэж дуусаагүй, дутуу байгаа ажлуудаа эрс эрчимжүүлж ажиллахыг хариуцсан дарга нар сайтар анхаарах. /Захирагчийн ажлын алба, Хэрэгжүүлэгч агентлагууд, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн өмчит, төсөвт үйлдвэрийн газрууд/ | | | | |
| 1. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/853 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Чингэлтэй дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсэг Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/253 дугаар захирамжаар байгуулагдсан.<br>Тус захирамжийн дагуу өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын явцын тайлан, мэдээг сар бүрийн 30-ны өдрийн дотор харьяа хэлтэс албадаас авч нэгтгэн тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын ханган сайжруулсан шахмал түлш нөөцлөх агуулахын судалгаа авч нэгтгэн нийт 10-н хорооны 41 байршилд нөөцлөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. “Таван толгой түлш” ХХК дүүргийн хэмжээнд 07 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 9,702 тонн сайжруулсан шахмал түлшийг нөөцлөөд байна.<br>**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:** Хорооллын доторх авто зам /15-р хороо/, хорооны доторх авто зам / 13 дугаар хороо/, хорооллын авто замын шинэчлэл, өргөтгөл / 13, 14, 15 дугаар хороо/, гудамжны тохижилт, шинэчлэл /14 дүгээр хороо/ ажил 80-90%-н гүйцэтгэлтэй.<br>**Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар:** 138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэгийн цогцолбор явах авто замын /ЧД-н 12 дугаар хороо/ ажил 30%-н гүйцэтгэлтэй.<br>**Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр**: Гудамж сайжруулах /10-19 дүгээр хороо/ ажил 100%-н гүйцэтгэлтэй байна.<br>“Чингэлтэй Тохижилт үйлчилгээ” ХХК давс 1000 тонн, өвлийн хувцас 200 ш, гутал 200, бээлий 400, түрдэг тэрэг, дугуй 300 ш, хүрз 300 ш, цавчуур 200 ш, аккумлятор 50 ш, дугуй 65 ш, хайрга дайрга 50 куб тус тус нөөцөлсөн.<br>“Найши трейд” ХХК нөөц үлдэгдэл 65 тонн давс, 11 тонн тусгай зориулалтын бодис нөөцөд бэлэн байна. 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нэмэлтээр 50 тонн давс, 20 тонн бодис нөөцлөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 50 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Үүрэг, даалгавар ХОЁР:** Инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлтийг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь дуусгах /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Замын хөгжлийн газар/ | | | | |
| 2. | Инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд 3 байршилд зураг төсвийн ажил хийгдэхээр болсон.<br>- 2022 оны 7 дугаар сарын 25-ны байдлаар 14 дүгээр хороонд Гүн нуурын жалга, 7, 10 11, 12 ,16 дугаар хороодын үерийн аюулаас хамгаалах далангийн зураг төсвийн ажил хийгдэж дууссан. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газраас нийт 75 у/м дэд бүтцийн шугамын ажил хийгдэж байгаа. Ажлын явц 70%-н гүйцэтгэлтэй. | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 50 |
| **Үүрэг, даалгавар ГУРАВ:** Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан 08 дугаар сарын 15-ны өдөр гэхэд тохижилт бүтээн байгуулалт, зам засварын ажлуудыг дуусгаж, эцэслэх. /Нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар/ | | | | |
| 3. | Дүүргийн хэмжээнд Нийслэлийн замын хөгжлийн газраас зам засварын ажлыг эхлүүлж, 2022 оны 7 дугаар сарын байдлаар 200м2 нөхөөсний ажил хийгдсэн байна. Тохижилтын ажлын чиглэлээр дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 14 ажил тусгагдсанаас 11 ажил нь хийгдэж дууссан байна.<br>Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 25 ажил төлөвлөгдсөнөөс 9 байршилд нь комисс ажиллаж, 10 байршилд зураг төсвийн ажил хийгдэж, 6 байршилд гэрээ байгуулагдан ажиллаж байна. | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 70 |
| **Үүрэг, даалгавар ДӨРӨВ:** Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө сургууль, цэцэрлэгийн өргөтгөл шинэчлэлт, засварын ажлыг дуусгах /Нийслэлийн Боловсролын газар, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар/ | | | | |
| 4. | Чингэлтэй дүүргийн хэмжээнд улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй боловсролын салбар дахь 5 төсөл арга хэмжээ байна.<br>1.Дүүргийн 4 дүгээр хороонд 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг 2022 оны 10 дугаар сард дуусгахаар төлөвлөн 07 дугаар сарын 27-ны байдлаар:<br>- Үндсэн ажил 80%<br>- Барилгын ажлын явц - 90%<br>- Заслын ажил - 90%<br>- Дулааны холболт - 100%-н гүйцэтгэлтэй хийгдсэн.<br>2022 онд 1938.0 сая төгрөгийн нэмэлт төсөв санхүүжилт тавигдан дараах ажлууд хийгдсэн. Үүнд:<br>- Халуун усны бойлер тавьсан<br>- Агааржуулалтын хоолойнууд хийгдсэн, далдлах ажил хийгдэж байна.<br>- Шатны болон бүх давхрын шалны плита хийгдсэн.<br>- Ариун цэврийн өрөөний хана шалны плита бүрэн хийгдсэн.<br>2.Дүүргийн 12 дугаар хороонд шинээр баригдаж байгаа 144 дүгээр бага сургууль, 276 дугаар цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил 2018 онд эхэлсэн, 2022 оны 08 дугаар сард дуусгах гэрээтэй.<br>- Гүйцэтгэлийн ажил - 80%<br>- Шаврын ажил - 100%<br>- Дотор цагаан замаскийн ажил - 80% | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Агааржуулалтын системийн ажил - 95%<br>- Гадна замын талбайн тэгшилгээ - 90%<br>- Хашааны ажлын гүйцэтгэл - 80%<br>- Дээврийн 2 дугаар үеийн хучилт 50%-н гүйцэтгэлтэй хийгдэж байна.<br>Дулаан, цахилгаан, сантехникийн ажил, гадна цэвэр, бохир шугамын ажил, цонх суулгах ажлууд бүгд бүрэн 100% хийгдсэн.<br>3.Дүүргийн 19 дүгээр хороонд баригдаж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил 2022 сарын 08 дугаар сард дуусгах гэрээтэй.<br>- Гүйцэтгэлийн ажил 70%<br>- Сантехникийн ажил 90%<br>- Цахилгааны монтажны ажил 90%<br>- Эко хавтангийн ажил 50%<br>- Явган замын ажлын гүйцэтгэл 95%-н гүйцэтгэлтэй явж байна.<br>Дотор тааз, хананы 1 дүгээр үеийн цагаан замаск татагдсан, гадна бохир, гаднах өрлөг, цутгалт, дээвэр, цонх суулгах ажил бүгд бүрэн дууссан.<br>4.Дүүргийн 5 дугаар хороонд баригдаж байгаа шинэ цэцэрлэгийн барилгын ажил 2022 оны 09 дүгээр сард дуусгах гэрээтэй.<br>- Гүйцэтгэлийн ажил 80%<br>Дотор шавар, гадна фасад, цонх, дотор замаск, цахилгаан, сантехникийн ажил бүрэн хийгдсэн.<br>5. Дүүргийн 1 дүгээр хороонд шинээр баригдаж байгаа 39 дүгээр цэцэрлэгийн ажил 2022 оны 09 дүгээр сард дуусгах гэрээтэй.<br>- Гүйцэтгэлийн ажил 95%<br>- Барилгын ажлын явц 90%<br>- Бүх шаврын ажил 90%<br>- Дулааны холболт 100%<br>- Шугам сүлжээний ажил 100%<br>- Фасадын ажил 100%<br>- Гадна тохижилт 95%<br>- Доод давхрын зоорын ажлыг нэмэлтээр хийж, гүйцэтгэл 80% хийгдсэн. Бүх давхрын шат, шалны ажил бүрэн 100% хийгдсэн. Ариун цэврийн өрөөний хана, шалны плита болон нойлын суултуурын угсралтын ажил хийгдэж байна.<br>Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар 15 хорооны 49 дүгээр сургууль "Цэвэр агаар" төслийн хүрээнд засварын ажил хийгдэж байна. Дээврийн ажил, бүх анги танхимын цонхыг шинээр суулгаж дууссан. Гадна фасадын ажил 80 %-н гүйцэтгэлтэй байна. | | | |
| **Үүрэг, даалгавар ТАВ**: Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаврыг яаралтай эрх шилжсэн байгууллагуудад хүргүүлэх, худалдан авах ажиллагааг яаралтай зарлаж дуусгах. /Нийт байгууллагууд/ | | | | |
| 5. | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Дүүргийн 2022 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах" тухай 15 дугаар | = | Үүрэг даалгаврын | 30 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тогтоолоор батлагдсан 22 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг төсөв, техникийн тодорхойлолт ирүүлэх тухай дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 143 дугаартай албан бичгийг Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. | | хэрэгжилт хангагдана | |
| **Үүрэг, даалгавар ЗУРГАА:** Намрын шинэ ургацын хүнсний ногоо гарахтай холбогдуулан ногоо тариалагч аж ахуйн нэгж байгууллагууд, хувь хүмүүсийг дэмжих, зөвлөн туслах үйлчилгээг шуурхай үзүүлэх, хүнсний ногоог нийслэлчүүдэд шууд гарт нь хүргэн худалдан борлуулах боломжоор нь хангахын тулд боломжтой олон борлуулалтын цэгүүдийн байршлыг нийслэл Улаанбаатар хотод гаргах ажлыг урьдчилан зохион байгуулж, ач холбогдол өгч ажиллах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар/ | | | | |
| 6 | Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу дүүргийн хороодод 2022 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 3/1802 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. Нийт 29 цэгт боломжит байршлын судалгааг ирүүлснээс 2 цэгт (4 дүгээр хороо, Бага тойруу гудамж Барилгачдын талбай, 5 дугаар хороо, Тусгаар тогтнолын талбай) төмс, хүнсний ногооны өргөтгөсөн үзэсгэлэн худалдааг гаргахаар, 27 цэгт жижиглэн худалдааг гаргахаар байршлын судалгааг нэгтгэн гарган НЗАА-д хүргүүлэн ажиллалаа.<br>Чингэлтэй дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсээс 19, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зуны түр сүүдрэвчтэй худалдаа, явуулын хоолны цэг, бусад жижиглэнгийн худалдаа эрхэлж буй 30 иргэн, аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 24 дүгээр хорооны Зунжин, Жигжидийн зуслангийн бүсэд 3 цэгт хүнсний ногооны худалдаа эрхэлж буй хувь хүмүүсийг дэмжин зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. | | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 70 |
| **Үүрэг, даалгавар ДОЛОО**: Засгийн газрын 2022 оны "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 218 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Боловсролын газар/ | | | | |
| 7 | Чингэлтэй дүүрэгт төрийн өмчийн 39 цэцэрлэг, төрийн бус өмчийн 15 цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг. Нийт 8410 хүүхдийн хүчин чадалтай. Хамран сургах тойргийн хүүхдийн статистик тоо 13231 Судалгаагаар 4821 хүүхэд СӨБ-д хамрагдахгүй байгааг харгалзан дараах ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Үүнд:<br>- Цэцэрлэгийн барилга ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх,<br>- Төрийн бус өмчийн цэцэрлэгт нэмэлт элсэлтээр хамруулах,<br>- Сул орон тоотоо төрийн өмчийн цэцэрлэгт хуваарилах<br>- Барилга түрээслэх арга замаар шийдэл гарган цэцэрлэгийн хүртээмж, хамрагдалтын тоог 100 %-д хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 30 |
| **Үүрэг, даалгавар НАЙМ:** Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Нэг тархи-Нэгдсэн систем" төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах тухай А/912 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд/ | | | | |
| 8 | Чингэлтэй дүүргийн ГХУСАЗСЗ-өөс алба хаагчдын албан хэрэгцээнд зориулж 10 ширхэг зайнаас тандагч, 16 ширхэг хаятеро гар станц, 1 ширхэг "Yamaha" мотоцикл хүлээн авч Замын цагдаагийн хэлтэс, Цагдаагийн Нэг дүгээр хэлтэс, Цагдаагийн Хоёрдугаар хэлтсийн алба хаагчдын албаны хэрэгцээнд ашиглаж байна. | = | Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана | 70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Зам тээврийн осол, хохирлоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, замын хөдөлгөөний хууль, дүрмийг сурталчлан таниулах зорилгоор иргэд хөдөө орон нутагт, зорчих хөдөлгөөн эхэлсэнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд “Аажуу явбал-Аяндаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээг иргэд, олон нийтэд сурталчлан, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг дагаж мөрдөх зөвлөмжийг ЧД-н Цагдаагийн газрын пейж хуудсаар өдөр тутам сурталчлан түгээх ажлыг зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт албан хаагчдыг үүрэгжүүлэн 544 удаагийн постер, богино хэмжээний видеог цахим сайтад байршуулан ажиллаа. | | | |

ЗАСАГ ДАРГА Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА М.НАВЧАА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ